

НЬЮ-БАЛАНС АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/147/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Нью-баланс аудит ХХК-ний партнер Б.Лхагвадорж
Утас: 99101901 Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com
Аудитор: Л.Наранбаатар
Утас: 99509636 Цахим хаяг: gerel_9636@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/157
танай _____ -ны № _____ -т

ЖАРГАЛАНТ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ш.БУРМАА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд хувьсах зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн ба улсын төсвөөс 497,392.5 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 9,870.2 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 86,262.7 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 500.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувьд хагас бие даалгаж, үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг сургалцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

Бусад асуудлын хэсэг

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хийж, түүнийг хангалттай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А. ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,024,908.17	94,874,803.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	9,870,285.59
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	9,870,285.59
3121	Төгрөг	00.00	9,870,285.59
31211	Төрийн сангийн харилцах	00.00	9,870,285.59
35	БАРАА МАТЕРИАЛ	68,024,908.17	85,004,518.17
351	Түүхий эд материал	3,985,800.00	2,607,750.00
35130	Эм боох материал	3,985,800.00	2,607,750.00
354	Хангамжийн материал	64,039,108.17	82,396,768.17
35410	Бичиг хэргийн материал	2,826,770.00	2,196,670.00
35420	Аж ахуйн материал	2,854,700.00	2,529,900.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	10.00
35450	Барилгын засварын материал	373,800.00	4,373,800.00
35460	Хүнсний материал	9,328,726.00	21,046,796.00
35470	Бусад хангамжийн материал	48,655,112.17	52,249,592.17
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,011,009,791.70	1,960,404,675.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,011,009,791.70	1,960,404,675.58
392	Биет хөрөнгө	2,004,136,991.70	1,953,531,875.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,096,525,905.00	2,096,525,905.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-187,189,113.33	-223,236,841.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,339,359.08	81,177,759.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,637,624.50	-35,140,910.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,384,795.73	37,116,632.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,345,854.29	-21,526,466.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,344,636.00	23,344,636.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,000,514.99	-7,444,242.19
39217	Ном	2,715,403.00	2,715,403.00
393	Биет бус хөрөнгө	6,872,800.00	6,872,800.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,872,800.00	6,872,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,079,034,699.87	2,055,279,479.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,681,120.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,681,120.00
413	Өглөг	00.00	3,681,120.00
4136	Бусад өглөг	00.00	3,681,120.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	3,681,120.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,079,034,699.88	2,051,598,359.34
51	Засгийн газрын хувь оролцоо	2,079,034,699.88	2,051,598,359.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,076,087,109.66	2,076,087,109.66
51101	Өмч: - төрийн	2,076,087,109.66	2,076,087,109.66
512	Хуримтлагдсан үр дүн	-1,539,166.74	-28,975,507.28
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,539,166.74	-1,539,166.74
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-27,436,340.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,486,756.96	4,486,756.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,079,034,699.88	2,055,279,479.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

0	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	530,154,911.83	595,335,117.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,654,478.83	509,072,417.00
120	Нийтлэг татварын бус орлого	53,654,478.83	11,679,917.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,654,478.83	11,679,917.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	53,654,478.83	11,679,917.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	497,392,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	497,392,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	476,500,433.00	86,262,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	413,499,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,145,433.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,145,433.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,855,100.00	86,262,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,855,100.00	86,262,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	508,727,765.95	622,771,457.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	508,727,765.95	622,771,457.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	507,915,185.90	622,270,957.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	322,287,996.60	372,844,201.17
210101	Үндсэн цалин	322,287,996.60	372,844,201.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,156,141.35	49,313,013.25
210201	Тэтгэврийн даатгал	28,264,176.35	34,355,927.29
210202	Тэтгэмжийн даатгал	3,222,992.00	3,739,270.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,578,392.00	2,991,418.19
210204	Ажилгүйдлийн даатгал	644,599.00	747,853.55
210205	Эрүүл мэндийн даатгал	6,445,982.00	7,478,543.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,352,690.00	58,512,199.90
210301	Гэрэл, цахилгаан	3,480,002.00	5,929,778.90
210302	Түлш, халаалт	50,312,688.00	50,171,721.00
210303	Цэвэр, бохир ус	1,560,000.00	2,410,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,238,499.00	12,788,110.00
210401	Бичиг хэрэг	692,100.00	135,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,999,586.00	7,163,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	890,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	305,433.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,866,380.00	4,599,200.00
2105	Нормативт зардал	17,727,069.75	55,921,980.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,265,550.00	1,378,050.00
210502	Хоол, хүнс	16,461,519.75	54,543,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,948,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,948,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,108,100.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	808,100.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,096,689.20	72,891,453.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,237,400.00	6,977,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,286,350.00	4,738,600.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,572,939.20	61,175,353.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	812,580.05	500,500.10
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	812,580.05	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	812,580.05	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	500,500.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	21,427,145.88	-27,436,340.54
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	21,427,145.88	-27,436,340.54

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	476,500,433.00	583,655,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	497,392,500.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	497,392,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	497,392,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	476,500,433.00	86,262,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	413,499,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,145,433.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,145,433.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,855,100.00	86,262,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,855,100.00	86,262,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	461,200,433.00	573,784,914.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	461,200,433.00	573,784,914.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	460,367,242.95	573,284,414.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,321,793.00	373,115,141.57
210101	Үндсэн цалин	207,468,055.00	294,860,926.57
210102	Нэмэгдэл	90,455,802.00	70,974,736.00
210104	Урамшуулал	22,397,936.00	7,279,479.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,122,344.95	49,042,072.84
210201	Тэтгэврийн даатгал	30,285,644.95	34,116,883.85
210202	Тэтгэмжийн даатгал	3,209,200.00	3,732,277.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,567,300.00	2,984,629.80
210204	Ажилгүйдлийн даатгал	641,800.00	746,307.47
210205	Эрүүл мэндийн даатгал	6,418,400.00	7,461,974.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,052,690.00	58,512,199.90
210301	Гэрэл, цахилгаан	3,480,002.00	5,929,778.90
210302	Түлш, халаалт	50,012,688.00	50,171,721.00
210303	Цэвэр, бохир ус	1,560,000.00	2,410,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,594,919.00	00.00
210401	Бичиг хэрэг	375,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	4,999,586.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	845,433.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,999,900.00	00.00
2105	Нормативт зардал	19,148,696.00	66,262,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	125,000.00	00.00
210502	Хоол, хүнс	17,773,796.00	66,262,000.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,249,900.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,781,800.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	6,781,800.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,108,100.00	1,110,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	808,100.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,236,900.00	21,243,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,237,400.00	16,743,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,999,500.00	4,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	833,190.05	500,500.10
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	812,580.05	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	812,580.05	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,610.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,610.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	500,500.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,300,000.00	9,870,285.59
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,300,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,300,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,300,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,300,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-15,300,000.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	9,870,285.59
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	9,870,285.59

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,076,087,109.66	4,486,756.96	-15,891,373.82	2,064,682,492.80
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	21,427,145.88	21,427,145.88
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,076,087,109.66	4,486,756.96	-1,539,166.74	2,079,034,699.88
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-27,436,340.54	-27,436,340.54
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,076,087,109.66	4,486,756.96	-28,975,507.28	2,051,598,359.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	583,755,200.00	573,284,414.31	10,470,785.69	98.21
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	583,755,200.00	573,284,414.31	10,470,785.69	98.21
210	Бараа, үйлчилгээний зардал	583,755,200.00	573,284,414.31	10,470,785.69	98.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	374,853,100.00	373,115,141.57	1,737,958.43	99.54
210101	Үндсэн цалин	304,187,800.00	294,860,926.57	9,326,873.43	96.93
210102	Нэмэгдэл	66,592,000.00	70,974,736.00	(4,382,736.00)	106.58
210104	Урамшуулал	4,073,300.00	7,279,479.00	(3,206,179.00)	178.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,327,400.00	49,042,072.84	3,285,327.16	93.72
210201	Тэтгэврийн даатгал	35,582,500.00	34,116,883.85	1,465,616.15	95.88
210202	Тэтгэмжийн даатгал	4,186,300.00	3,732,277.27	454,022.73	89.15
210203	ҮОМШӨ ний даатгал	3,348,600.00	2,984,629.80	363,970.20	89.13
210204	Ажилгүйдлийн даатгал	838,000.00	746,307.47	91,692.53	89.06
210205	Эрүүл мэндийн даатгал	8,372,000.00	7,461,974.45	910,025.55	89.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,512,700.00	58,512,199.90	500.10	100.00
210301	Гэрэл цахилгаан	6,000,000.00	5,929,778.90	70,221.10	98.83
210302	Түлш, халаалт	50,012,700.00	50,171,721.00	(159,021.00)	100.32
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,410,700.00	89,300.00	96.43
2105	Нормативт зардал	71,322,000.00	66,262,000.00	5,060,000.00	92.91
210502	Хоол, хүнс	71,322,000.00	66,262,000.00	5,060,000.00	92.91
2106	Эд хогшил худалдан авах	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,110,000.00	1,110,000.00	-	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	1,110,000.00	1,110,000.00	-	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	21,630,000.00	21,243,000.00	387,000.00	98.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,130,000.00	16,743,000.00	387,000.00	97.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,500,000.00	-	100.00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	583,755,200.00	583,154,699.90	600,500.10	99.90
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	497,392,500.00	497,392,500.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	497,392,500.00	497,392,500.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	86,362,700.00	85,762,199.90	600,500.10	99.30
132001	Орон нутгийн төсвөөс	86,362,700.00	85,762,199.90	600,500.10	99.30
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,870,285.59	(9,870,285.59)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	29.00	29.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Жаргалант сумын Хүүхдийн цэцэрлэг нь тухайн орон нутаг сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг эрхэлж байна. Тус хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд “Хүүхэд бүрийн эрүүл аюулгүй суралцах орчныг бүрдүүлж, багш бүр сайн туршлагаа түгээн дэлгэрүүлж, хамтран суралцах үйл явцыг идэвхжүүлэн үнэлгээнд суурилсан хөгжил, оролцооны арга зүйг дэмжин хэрэгжүүлнэ” гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд 9 зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Хүүхдийн цэцэрлэгийн захирал нь аймгийн Жаргалант сумын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хийж, түүнийг хангалттай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна. Засгийн газар болон Боловсрол шинжлэх ухааны яамнаас дараах шийдвэрүүдийг гаргасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:

1. Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
2. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ” баталсан байна.
3. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
4. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус батлан хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 3 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Боловсролын яам, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,755.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	9,870.3	(9,870.3)
Авлага	-	-	-

Бараа материал	68,024.9	85,004.5	(16,979.6)
Үндсэн хөрөнгө	2,011,009.8	1,960,404.7	50,605.1
Нийт хөрөнгө	2,079,034.7	2,055,279.5	23,755.2
Өр төлбөр	-	3,681.1	(3,681.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,079,034.7	2,051,598.4	27,436.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,079,034.7	2,055,279.5	23,755.2

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, өр төлбөр данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Нийт хөрөнгө, эздийн өмч өмнөх оноос буурсан нь үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардал гол нөлөөг үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 497,392.5 мянган, орон нутгийн төсвөөс, 86,262.7 мянган, төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Байгууллагын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны А/392 тоот тушаалаар төсвийн сар, улирлын хуваарь өөрчлөлт оруулсан байна.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувь хагас бие даалгаж, үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг сургалцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 497,392.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 86,262.7 мянган орон нутгийн төсвөөс бүрдүүлж ажилласан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн ба улсын төсвөөс 497,392.5 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 9,870.2 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 86,262.7 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 500.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 573,284.8 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний зардлын төсвийг 10,470.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Боловсролын стандарт, сургалтын	359,817.9	356,266.5	3,551.2	97.7

	төлөвлөгөө /81834/				
2	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах /818365/	60,868.4	59,496.3	1,372.0	97.7
3	Цэцэрлэгийн хүүхдийн хоол /81807/	71,322.0	66,262.0	5,060.0	92.9
4	Эрүүл мэндийн үйлчилгээ/81605/	1,500.0	1,191.0	309.0	79.4
5	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх/81823/	1,500.0	1,422.0	78.0	94.8
6	Хүүхдэд эзлтэй сургалтын орчин/81816/	2,384.3	2,384.3		100
7	Нийтлэг үйлчилгээ/80112/	23,850.0	23,750.0	100.0	99.6
8	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/	62,512.7	62,512.7		100
9	Нийт дүн	583,755.3	573,284.8	10,470.7	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус Хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Нью-баланс аудит ХХК-ний ахлах аудитор Л.Наранбаатар гүйцэтгэж, хяналтыг Нью-баланс аудит ХХК-ийн захирал Б.Лхагвадорж анхан шатанд хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нью-баланс аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 508,748.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10,174.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг дүнг 8,139.9 мянган төгрөгөөр тооцсоныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно. Тус байгууллагад дэд болон орлогч даргын орон тоо бүтэц, орон тоонд нь батлагдаагүй, албан тушаалын автомашин байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Жаргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зардлын 56,133.4 мянган төгрөгийн 6 гүйлгээ, орлогын 466,974.9 мянган төгрөгийн 30 гүйлгээг тус тус шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулийн холбогдох заалт, 2022 онд шинээр хэрэгжиж эхэлсэн журам заавруудын хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрсэн болно. Үүнд:

Хүүхдийн хоолны зардлыг нормативаас 1,630.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ Засгийн газрын 2019 оны 450 дугаар "Хоолны зардлын норматив тогтоох тухай" тогтоолтой нийцэхгүй байгаа ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Жаргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага хүргүүлээгүй ба зөвлөмжийг хүргүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 550,461.4 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, албан шаардлага 1-ийг хүргүүлж, 2 зөвлөмжийг хүргүүлсэн. Үүнээс 523,108.3 мянган төгрөг нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил болно.

5.1. Залруулга

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 22,041.0 мянган төгрөгийн залруулга хийсэн болно. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдаж авсан 10,570.2 мянган төгрөгийн зардлыг мөнгөн гүйлгээний тайлангийн биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнаагүй байсныг аудитын хугацаанд залруулсан
- Мэдээлэл технологийн үйлчилгээнд 1,100,0 мянган төгрөг зарцуулж Мөнгөн гүйлгээний тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөн боловч үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй тул залруулга хийсэн
- Орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийн үлдэгдэл 500.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн боловч мөнгөн гүйлгээний тайланд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй тул залруулсан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний болон эцсийн үлдэгдлийн зөрүүг нийт цэвэр мөнгөн гүйлгээтэй тулгахад зөрүүтэй 9,870.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн тул залруулсан.

5.2. Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3. Албан шаардлага

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зардлын 56,133.4 мянган төгрөгийн 6 гүйлгээ, орлогын 466,974.9 мянган төгрөгийн 30 гүйлгээг тус тус шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөр данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, төсвийг зохистой зарцуулаагүйгээс 3,681.1 мянган төгрөгийн өр төблөр үүсгэж ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

3. Норм, норматив мөрдөөгүйтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хүүхдийн хоолны зардлыг нормативаас 1,630.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ Засгийн газрын 2019 оны 450 дугаар "Хоолны зардлын норматив тогтоох тухай" тогтоолтой нийцэхгүй байгаа ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан норм нормативыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрүүтэй илэрхийлсэн	1	10,570.2			1	10,570.2	1	10,570.2				
Тайлагналын алдаа	1	1,100.0			1	1,100.0	1	1,100.0				
Зардлаар хүлээн зөвшөөрөөгүй	1	500.5			1	500.5	1	500.5				
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл зөрүүтэй	1	9,870.3			1	9,870.3	1	9,870.3				
Дүн	4	22,041.0			4	22,041.0	4	22,041.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэж ажилласан	1	3,681.1					1	3,681.1				
Дүн	1	3,681.1					1	3,681.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулаагүй	36	523,108.3		1	523,108.3		
Дүн	36	523,108.3		1	523,108.3		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Норм норматив мөрдөөгүй	1	1,630.9				1	1,630.9
Дүн	1	1,630.9		1	523,108.3	1	1,630.9
Нийт дүн	37	524,739.2		1	358,882.2	1	3,317.8

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: *W/24*

Л.МАНДАХНАРАН ОГНОО: *II/21*

БЭЛТГЭСЭН:

НЬУ БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
 ЗАХИРАЛ

Bm

Б.ЛХАГВАДОРЖ *2023.04.24*